

Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр

2015 оны 5-р сарын 9-10-нд

Эрчим хүч - түүнийг шувуудад ээлтэй байлгая!



World Migratory Bird Day

Эрчим хүчний хэрэглээ дэлхий даяар өсөн нэмэгдэж буй өнөө үед сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх технологийг сайжруулах замаар агаар дахь нүүрс төрөгчийн хэмжээг бууруулах нь бидний ирээдүйн чухал асуудал болжээ. Түүнчлэн биологийн олон янз байдал, тэр тусмаа нүүдлийн шувуудыг анхаарахгүй бол эрчим хүч нь байгальд ээлтэй болж чадахгүй. “Эрчим хүч, түүнийг шувуудад ээлтэй болгоё” уриан дор тэмдэглэх гэж буй “Дэлхийн Нүүдлийн Шувуудын Өдөр 2015”-н гол зорилго нь эрчим хүч үйлдвэрлэгч технологиос нүүдлийн шувууд, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга зам хайхын ач холбогдлыг тодотгон харуулах явдал юм.

Жил бүр сая сая нүүдлийн шувууд эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч төрөл байгууламжийн сөрөг нөлөөлөлд өртдөг. Тухайлбал, өндөр хүчдлийн шугамын утасыг мөргөх, эсвэл цахилгаан гүйдэлд цохиулан энддэг. Мөн эрчим хүчний байгууламжаас дайжиж олон олон шувууд амьдрах орчны алдагдал, доройтолд өртөж байна. Гэвч сэргээгдэх эрчим хүчийг байгальд ээлтэйгээр үйлдвэрлэснээр цаг уурын дулаарлаас нүүдлийн шувуудад үзүүлэх нөлөөллийг тодорхой хэмжээнд бууруулж чадах ч тэдгээр нь зөв төлөвлөлт, зөв загвар, эрсдлийн тооцоололгүй бол энэ нь эргээд нүүдлийн шувуудад сөрөг нөлөөлж болзошгүй.

Дэлхий дээрх амьд биетийг хамгаалах амин чухал алхам бол эрчим хүчийг амьд байгальд ээлтэйгээр үйлдвэрлэх явдал тул бүс нутаг, үндэстэн, олон улсын хэмжээний бүхий л шатанд нүүдлийн шувуудыг хамгаалах шаардлагатай ба үүнд тухайн улсын засгийн газар, байгаль хамгааллын байгууллага, судлаач, эрчим хүчний салбарыхан болон олон нийт бүгд харилцан тохиролцож хамтран ажиллах нь чухал. Ингэж чадвал, нүүдлийн шувууд, тэдгээрийн амьдрах орчинд ээлтэйгээр эрчим хүч үйлдвэрлэхийн ач тусыг олж харж чадна.

Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр

Нүүдлийн шувуудыг амьдрах орчинтой нь хамт хамгаалах санааг олон нийтэд таниулах зорилготойгоор “Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр”-ийг 2006 оноос хойш тэмдэглэсээр ирсэн билээ. НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрөөс (UNEP) зохицуулагддаг олон улсын хоёр том гэрээ болох Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах тухай конвенц (CMS), Африк-Евразийн нүүдлийн усны шувуудыг хамгаалах тухай гэрээг энэ жил уг үйл ажиллагааг зохион байгуулж байна. Жилээс жилд хамтран ажиллах байгууллагууд нэмэгдсээр байгаа ба Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Байгаль орчин, Байгаль хамгаалал, Барилга, Цөмийн Аюулгүй Байдлын Яамны (BMUB) дэмжлэгтэйгээр энэ жил зохион байгуулагдаж буй цохон тэмдэглэхэд таатай байна. Манай Монгол оронд жил бүр Монголын шувуу судлалын нийгэмлэг зохион байгуулдаг билээ.

Ингээд 2015 оны 5-р сарын 9-10-нд “Дэлхийн Нүүдлийн Шувуудын Өдөр”-ийг хамтдаа тэмдэглэхийг уриалж байна. Лекц, семинар, шувуучлах аялал зохион байгуулах, үзэсгэлэн гаргах, шувуудад ээлтэй эрчим хүчний байгууламжтай танилцах зэрэг бусад үйл ажиллагаа зохиосон бол бүртгүүлж, дэлхийн бусад оронд тэмдэглэж буй хүмүүстэй нэгдээрэй.

Дараах хаягаар зочилж “Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр”-ийн тухай нэмэлт мэдээллийг олж, зурагт хуудас, ил захидал, стикер зэргийг захиалж, өөрийн зохион байгуулж буй үйл ажиллагааг даян дэлхийн бусад хүмүүстэй хуваалцаарай (www.worldmigratorybirdday.org).

Тантай хамт “Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр 2015”-ийг тэмдэглэхдээ таатай байх болно!

Дэлгэрэнгүй мэдээлэл авч, үйл ажиллагаагаа бүртгүүлэх бол дараах хаягаар орно уу www.worldmigratorybirdday.org

Холбоо барих:

Ms Dunia Sforzin, UNEP/AEWA Нарийн бичгийн дарга

Утас: +49 (0)228 815 2454

Факс: +49 (0)228 815 2450

Ц-шуудан: contact@worldmigratorybirdday.org

